

**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо: 2023 оны 3 сарын 18-ны өдөр

Цаг: 10:00

Хэлбэр: Цахим/Zoom/

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ тогтоолыг танилцуулах;
4. ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох;
5. Нээлттэй болон хаалттай хүрээнд Бонд гаргах тухай хэлэлцэн батлах
6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай хэлэлцэн батлах
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах;
8. Бусад

Тооллогын комиссын дарга М.Уянга хурлын ирц танилцууллаа.

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны 3 сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцаа буюу 1,508,116,708 ширхэг хувьцаанаас тус өдрийн хуралд 1,504,981,127 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид ирсэн нь саналын эрх бүхий хувьцааны 99,8% болж ирц бүрдсэн боловч итгэмжлэлээр оролцсон 1 хувьцаа эзэмшигчийн итгэмжлэл нь нотиратаар баталгаажгаагүй тул хүчингүйд тооцсон. Хурлын ирц 977,946,683 ширхэг буюу 64,8% байна. Энэ нь хурлын ирц Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д заасан болон Компанийн дүрэмд заасантай тус тус бүрэн нийцсэн тул хурлыг нээж үг хэлнэ үү хэмээн хурлын дарга Ч.Чинзориг таныг урьж байна.

Хурлын дарга Ч.Чинзориг: Сайн байцгаана уу. Та бүхэнд хурал нээснийг мэдэгдэж байна.

Ингээд хурлын дэгийг танилцуулъя.

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;	5 минут	Гүйцэтгэх захирал
Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;	5 минут	Аудитын хорооны дарга
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын №2 “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг танилцуулах;	5 минут	Хурлын дарга
ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох;	5 минут	Хурлын дарга

Нээлттэй болон хаалттай хүрээнд Бонд гаргах эрхийг ТУЗ-д олгох	10 минут	Хурлын дарга
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах эрхийг ТУЗ-д олгох;	10 минут	Хурлын дарга
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах	5 минут	Гүйцэтгэх захирал
Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	20 минут	Хурлын дарга,
Саналын хуудсаар санал авах	10 минут	Тооллогын комисс
Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх	30 минут	Тооллогын комисс
Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулах	10 минут	Хурлын дарга

Та бүхэнд хурлын дэгийг танилцууллаа.

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг гүйцэтгэх захирал Ганхүлэгийг танилцуулахыг урьж байна.

Гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг: Та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Манай компани нь Зээлийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйлчилгээ, Валют арилжаа гэсэн 3 төрлийн тусгай зөвшөөрөлтэйгээр 8 төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. Нийт 6 ажилтантай, дүрмийн сан 3,4 тэрбум төгрөг, 2022 оны эцсийн байдлаар Итгэлцлийн үйлчилгээгээр 3,4 тэрбум төгрөгийн өглөгтэй, 16,6 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байна.

2022 онд 2 удаа ХЭХ хуралдсан бөгөөд дээрх 7 төрлийн багц шийдвэрүүдийг гаргасан байна. Мөн ТУЗ нь 13 удаагийн хурлаар 8 төрлийн багц шийдвэрүүдийг гаргасан байна. Онцлох үйл явдлууд гэвэл

1. Хаалттай хүрээнд 377,029,177 ширхэг хувьцаа нэмж гарган 7,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татан эргэлтийн хөрөнгөнд зарцуулсан.
2. Эх үүсвэр татсантай холбогдуулан СЗХ-ны 2019 оны 12 сарын 27-ны өдрийн 441 тоот тогтоолын хэрэгжилтийг хангаж 3,4 тэрбум төгрөгийн дүрмийн сантай болсон.
3. Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэгч ББСБ болсноор урт хугацаатай 2,2 тэрбум төгрөгийн Итгэлцэл татан төвлөрүүлж шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлсэн.
4. Монгол улсад нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлж, “НОГООН ЗЭЭЛ”-ийг дэмжихийн төлөөх хамтарсан тунхаг бигчигт нэгдсэн.

2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайландаа хөндлөнгийн аудитын компани болох Шинэ Их тэрбум Аудит ХХК-г сонгон хийлгэсэн. Дүгнэлтээр компанийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд

Санхүүгийн олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой иэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн.

Санхүүгийн голлох үзүүлэлтийн хувьд нийт хөрөнгө өмнөх оноос 157% өсөлт буюу 11 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, өөрийн хөрөнгийн хэмжээ 143% буюу 8,4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хүүний орлогын хувьд 1,9 тэрбум төгрөг буюу 168% өсөлт хийсэ бол цэвэр ашгийн хувьд 105% буюу 1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Зах зээлийн хувьд харьцуулаад үзэхэд ББСБ-ын салбарын хувьд нийт орлогын өсөлт 66,5% байхад манай компанийн хувьд 174,7% өсөлт үзүүлсэн байна. цэвэр ашгийн өсөлт салбарын хувьд 49% байсан бол манай байгууллага 105% өссөн байна. Салбарын зээлийн дундаж хүү 3,1% байгаа бол манай зээлийн дундаж хүү 2,7% байгаа нь зах зээлд өрсөлдөхүйц байж чадаж байна. Салбарын голлох үзүүлэлт болох чанаргүй зээлийн хүү салбарын хувьд 11,5%-тай байхад манай байгууллагын хувьд 3,1% байж амжилттай ажилласан байна.

За та бүхэн асууж тодруулах зүйл байвал асуулт харилтын хэсэгт тодруулна уу. Баярлалаа.

Хурлын дарга Ч.Чинзориг:

За Ганхүлэг захиралдаа баярлалаа. Одоо Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дарга Энх-Амгалан таныг урьж байна.

Б.Энх-Амгалан: За та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Тандэм Инвэст ББСБ”ХК-ийн Аудитын хорооны дүгнэлтийг та бүхэндээ танилцуулъя. Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм, хууль тогтоомж, хувь нийлүүлэгчээс олгогдсон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон хяналт тавин ажилласан болно Компани 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Шинэ их Тэрбум Аудит ХХК-ийг хөндлөнгийн аудитын компаниар сонгон ажилласан.

Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл:

Цалин	183.6 сая төгрөг
Аудит, мэргэжлийн үйлчилгээ	3.1 сая төгрөг
Түрээс	18.8 сая төгрөг
Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал	23.3 сая төгрөг
Маркетинг сурталчилгаа	1.2 сая төгрөг
Зохицуулал үйлчилгээний хураамж	166.8 сая төгрөг
Зээл барагдуулахтай холбоотой зардал	0.9 сая төгрөг
Албан томилолт	26.7 сая төгрөг
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	228.0 сая төгрөг

Авлага, өглөгийн тухайд тайлант хугацаанд Итгэлцлийн үйлчилгээний 3,4 тэрбум төгрөгийн өглөгтэй, Итгэлцлийн хүүний өглөг, татварын өглөг нийлээд 301,4 сая төгрөгийн өглөгтэй байсан.

Үндсэн хөрөнгийн тухайд 2022 оны эцсийн байдлаар 486,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Компанийн 2022 оны санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагааг санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад баримт, тайлантай тулган хянахад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харьяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй.

Хурлын дарга Ч.Чинзориг: Аудитын хорооны дарга Энх-Амгаландаа баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудал болох “Ногдол ашиг хуваарилах тухай” асуудал байгаа. Компани 2021 онд мөн ашигтай ажиллаж нийт 887 хувьцаа эзэмшигчдэд 9,72,133,677 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан. 2021 оны ногдол ашгийг 2022 оны 6 сарын 20-ний өдрөөр тасалбар болгон хуваарилж дууссан байна.

Мөн компани 2022 онд ашигтай ажиллаж нэгж хувьцаанд 1 төгрөг 32 мөнгөний ногдол ашиг хуваарилахаар ТУЗ-ийн 2023 оны 2 сарын 6-ны өдрийн №4 тоот тогтоолоор тогтоосонг та бүхэндээ танилцуулж байна. Өмнөх жилийн адил жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг компаниас 2023 оны 12 сарын 29-ний өдрийн дотор шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Хурлын дарга Ч.Чинзориг: Дараагийн хэлэлцэх асуудал маань ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох;

ТУЗ-ийн гишүүн Золжаргал нь гадаад улсад суралцахтай холбогдуулан өөрийн хүсэлтээр ТУЗ-өөс гарах хүсэлтийг гаргасантай холбогдуулан ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, нөхөн томилох зэрэг асуудал оруулсан. Та бүхэн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулгатай танилцан саналаа саналын хуудсаараа өгнө үү. Товч танилцуулгыг хүн бүрээр нэг бүрчлэн танилцуулъя.

Хурлын дарга Ч.Чинзориг: МХБ ХК-д бүртгэлтэй бусад 4 компанитай харьцуулбал манай компани бонд гаргаж байгаагүй түүнчлэн ХБҮЦ гаргаж байгаагүй. Бидэнд эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, ашгаа өсгөх бүрэн боломж бололцоо байгааг ТУЗ-ийн зүгээс өмнөх хурлуудад удаа дараалан санал болгож байсныг үндэслэн 2023 он болон богино дунд хугацаанд энэхүү хурлаар 5,6 асуудал болгож хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр дараах асуудлуудыг оруулж байна. 2022 оны ээлжит бус хурлаас нэмэлт хувьцаа гаргах шийдвэрийг гаргасан бөгөөд энэ ондоо энэхүү нэмэлт хувьцааг гаргаж эргэлийн хөрөнгөө нэмэгдүүлж бонд, ХБҮЦ гаргах саналтай байгаа юм.

Хэлэлцэх асуудал 5: ТУЗ-ийн зүгээс богино болон дунд хугацаанд гаргах 12,000,000,000 төгрөгийн бондыг тухайн үеийн цаг үетэй уялдуулан 2 үе шаттай гаргах,

Хэлэлцэх асуудал 6: Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх бодлогын хүрээнд ТУЗ-ийн зүгээс богино болон дунд хугацаанд гаргах 10,000,000,000 төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах эрхийг тус тус ТУЗ-д олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр оруулсан байна.

Гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг: Хамгийн сүүлийн хэлэлцэх асуудал буюу ТУЗ-ийн 2023 оны төсөв батлах тухай байна.

Та бүхэн ТУЗ-ийн зардлын төсөвтэй танилцан саналаа өгнө үү. Слайдаар гаргасан байгаа дүнг би та бүхэнд уншиж танилцуулж өгөө.

№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Цалин /дарга/	1	710,000	8,520,000
2	Цалин /гишүүд/	8	550,000	52,800,000
3	Цалин/ нарийн бичгийн дарга/	1	550,000	6,600,000
4	ТУЗ-ийн ээлжит хурлын зардал	4	350,000	1,400,000
5	ТУЗ-ийн ээлжит бус хурлын зардал	6	350,000	2,100,000
6	ТУЗ-ийн хурал уулзалтын зардал			25,000,000
4	ТУЗ-н бичиг хэрэг			500,000
5	ТУЗ-ын томилолт			20,000,000
Нийт дүн				116,920,000

Хурлын дарга Ч.Чинзориг: Ганхүлэг захиралдаа баярлалаа

Хэлэлцэх асуудлууд дууссан байна. Ингээд хувьца эзэмшигчдээсээ санал асуулга аваад явъя. Та бүхэн микрофоноо асаагаад асуултаа асуугаарай. Чат хэсэгт бичиж асууж бас болноо.

Хувьцаа эзэмшигч Л.Тунгалаг: Сайн байцгаана уу. Надад нэг асуулт байна. Бонд хэзээ гаргах вэ

Хурлын дарга Ч.Чинзориг: Богино болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөт ажлын хүрээнд хийгдэх ажил одоогоор яг хэдэн сард гэсэн хугацаа байхгүй байна.

Хувьцаа эзэмшигч Л.Тунгалаг: За баярлалаа. Өөр асуулт байхгүй байна.

Ч.Чинзориг: За хувьцаа эзэмшигчдээс асуулт байхгүй бол асуулт хариултаа өндөрлөөд санал хураалтаа явуулах уу.

Тооллогын комиссын дарга М.Уянга: Тооллогын комиссын дүн гарч дууслаа. Тооллогын комисст даргаар М.Уянга миний бие, гишүүдээр Д.Бадамдулам, Г.Азбилэг нар ажиллаа. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны 3-р сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дээрх 8 асуудлыг хэлэлцэж саналыг саналын хуудсаар авч баталгаажууллаа. Ингээд тооллогын комиссын шийдвэрийг танилцуулъя.

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2023 оны 3 сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцаа буюу 1,508,116,708 ширхэг хувьцаанаас тус өдрийн хуралд 1,504,981,127 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид ирсэн нь саналын эрх бүхий хувьцааны 99,8% болж ирц бүрдсэн боловч итгэмжлэлээр оролцсон 1 хувьцаа эзэмшигчийн итгэмжлэл нь гарын үсэг зурж ирсэн боловч нотиаратаар баталгаажаагүй тул хурлын ирц 977,946,683 ширхэг буюу 64,8% байна. Энэ нь хурлын ирц Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д заасан болон Компанийн дүрэмд заасантай тус тус бүрэн нийцсэн.

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 64,8% саналаар зөвшөөрч баталсан.
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 64,8% саналаар зөвшөөрч баталсан.
3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,7% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 64,8% саналаар зөвшөөрч баталсан.
4. Хаалттай хүрээнд бонд гаргах талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 64,8% саналаар зөвшөөрч баталсан.
5. Нээлттэй болон хаалттай хүрээнд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 64,8% саналаар зөвшөөрч баталсан.
6. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 64,8% саналаар зөвшөөрч баталсан.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  /Б.Бадамцэцэг/

Хурлын дарга:



 /Ч.Чинзориг/